

Монгол Улс дах бүх нийтийн эрх зүйн боловсрол

П.БАДАМРАГЧАА

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ЭРХ ЗҮЙН ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖЕР

Бүх нийтийн эрх зүйн боловсрол

Зорилго: Иргэд эрхээ мэдэж, өдөр тутмын амьдралдаа тулгарч болох асуудлаас урьдчилан сэргийлэх, нэгэнт тулгарсан асуудлаа хуулийн дагуу шийдвэрлэхэд тус дөхөм болох ур чадвар мэдлэг олгох

Нийтлэг сэдвүүд: Гэр бүлийн харилцаа, гэрлэлт цуцлалт, хүүхдийн тэтгэмж, өв залгамжлал, хөдөлмөрийн харилцаа, хөрөнгийн маргаан, нийгмийн халамж, үйлчилгээ, СӨХ/орон байрны асуудал, эрүүгийн хэрэг, зөрчил, нийгмийн дэг журам гэх мэт өдөр тутамд тулгамддаг, амьдралын чанарт нөлөөлөх бэрхшээлүүд

Бүх нийтийн боловсролын үр нөлөө:

- ▶ Чадавхжих: Өөрт тулгарсан асуудлаа өөрөө шийдвэрлэх/ хөөцөлдөх мэдлэг, чадвар, итгэл бий болгох
- ▶ Эрт “оношлох” : Тулгамдсан асуудлаа аль болох газар авхуулахгүй эрт шатанд таньж мэдэх чадвар суулгах
- ▶ Шударга ёсны тэгш хүртээмж: Аливаа нийгмийн байдал, бэрхшээл, байршил, нас, хүйсээс үл хамааран шударга ёс тогтоолгох, эрх ашгаа хамгаалуулах боломж тэгш байх (хууль зүйн үйлчилгээ авах, цагдаа, шүүхэд хандах гм)

Эрх зүйн үндэс, бодлогын баримт бичиг

- ▶ Монгол Улсын Үндсэн хууль – иргэн хууль, эрхээ мэдэх, хамгаалуулах эрхтэй
- ▶ Боловсролын тухай хууль – иргэний болон эрх зүйн боловсрол олгох зорилтыг тусгасан.
- ▶ Засгийн газрын тогтоол, үндэсний хөтөлбөрүүд: “Бүх нийтийн эрх зүйн боловсролын үндэсний хөтөлбөр”, Хүний эрх, авлигын эсрэг, хууль дээдлэх соёлыг төлөвшүүлэх бодлогын баримт бичгүүдтэй уялдан хэрэгждэг.
- ▶ “Эрх зүйн албан бус сургалтын хөтөлбөр”, “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, “Эрх зүйн сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөр”, “Эрх зүйн сурталчилгааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Сум, дүүрэгт эрх зүйн хөтөч (ухуулагч)-ийн ажиллах журам”, “Хууль зүйн салбарын үйл ажиллагаанд холбогдох мэдээ, мэдээлэл бэлтгэж, олон нийтэд хүргэх журам” зэрэг бодлогын баримт бичиг өмнө үйлчилж байв.

Үзэл баримтлалын өөрчлөлт

- ▶ 2016 оноос Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэй Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх нь төсөл 4 жилийн хугацаатай хэрэгжиж олон улсын хамтарсан томоохон төслийн хүрээнд үзэл баримтлалын гол өөрчлөлт хийгдсэн
- ▶ Хууль зүй дотоод хэргийн яамны манлайллаар иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх үзэл санаа бодлогын баримт бичиг болж батлагдан хэрэгжсэн.
 - ▶ Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлагын судалгаа
 - ▶ Үндэсний хэмжээний зөвлөлдөх уулзалт
 - ▶ Үндэсний хөтөлбөр
 - ▶ Эрх зүйн биет хөтөч
 - ▶ Эрх зүйн цахим хөтөч

Мэдээлэх  Чадавхжуулах

Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал – 2016 оны судалгаа

- ▶ Иргэдийн өдөр тутмын амьдралд хууль, эрх зүйн мэдлэгтэй холбоотой тулгарч байгаа бэрхшээл, түүнийг шийдвэрлэж байгаа арга зам, нөхцөл байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар судалж үзэхэд
- ▶ 54.8 хувь хууль, эрх зүйн үр дагавар бүхий ямар нэг бэрхшээл тохиолдсон
 - ▶ тэдний 50.5 хувь түүнийг шийдвэрлэх ямар нэг оролдлого хийгээгүй байна.
 - ▶ 36.8 хувь юу ч хийгээд нэмэргүй гэж бодсон,
 - ▶ 25.5 хувь юу хийхээ мэдэхгүй байсан,
 - ▶ 17.3 хувь тийм ноцтой асуудал биш гэж үзсэн,
 - ▶ 15.7 хувь ямар эрх байгаагаа мэдээгүй гэж хариулсан байна.
- ▶ Харин хууль зүйн туслалцаа авсан иргэдийн
 - ▶ 40.8 хувь найз нөхөд, хамаатан садан, танил талдаа хандсан,
 - ▶ 14.5 хувь холбогдох төрийн байгууллагад хандсан,
 - ▶ 15.6 хувь цагдаагийн байгууллагад хандсан,
 - ▶ 14.5 хувь хуульч, өмгөөлөгчид хандсан байна.
- ▶ “Хэрэв ямар нэг бэрхшээл тохиолдвол хаашаа хандахаа мэдэх үү?” гэсэн асуултад 57.1 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан байна.

Урт хугацааны бодлогын баримт бичиг

- ▶ НҮБ-ын “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”-ийн 16-р зорилт

”Тогтвортой хөгжлийн төлөөх тайван, бүгдийг хамарсан нийгмийг дэмжих, шударга ёсыг бүгдэд хүртээмжтэй болгох, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүгдийг хамарсан тогтолцоог бий болгох”

НҮБХХ-ийн Эрх зүйн чадавхыг дээшлүүлэх асуудал эрхэлсэн хорооноос хийсэн судалгаагаар дэлхийн хэмжээнд “иргэд хуулийн мэдлэг, мэдээлэлгүйгээс өөрт хуулиар олгогдсон эрх, боломжоо эдэлж чадахгүй байна”, “өөрийнхөө хууль ёсны ашиг сонирхол, зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байна”, “төрийн үйлчилгээ иргэдэд хүртээмжтэй биш байна” гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг бөгөөд 4 тэрбум гаруй хүн хуулийн үйлчлэл хамгаалалтаас гадуур амьдарч байгааг онцлон тэмдэглэжээ.

- ▶ “АЛСЫН ХАРАА: Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.

Зорилт 5. Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.

Иргэдийг эрх зүйн хувьд чадавхжуулах

“Legal empowerment” – Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх

Иргэд, ялангуяа эмзэг бүлэг хууль, эрхээ мэдэхээс гадна, түүнийг бодитоор хэрэгжүүлэх, зөрчигдвөл хамгаалуулах, төрийн байгууллагаас хариуцлага нэхэх чадавхтай болох үйл явц юм.

Мэддэг байх → Боловсрол

Ашиглаж чаддаг байх → Чадавхжуулалт

Иргэд эрх зүйн бүх асуудлаар мэдээлэл, мэдлэгтэй байх шаардлагагүй, гагцхүү мэдээллийн үнэн зөв, найдвартай сувгаас өөрт хэрэгтэй, шууд авч хэрэглэж болохуйц мэдээллээ олж авч ашиглаж мэддэг болгох үзэл баримтлал давамгайлах болжээ.

Эрх зүйн боловсрол болон Эрх зүйн чадавхжуулалтын ялгаа

	Эрх зүйн боловсрол	Эрх зүйн чадавх нэмэгдүүлэх Legal empowerment
Гол зорилго	Хууль, эрх зүйн мэдлэг олгох	Эрхээ хэрэгжүүлэх чадвар бий болгох
Төвлөрөл	Мэдээлэл, ойлголт	Үйлдэл, оролцоо
Хэлбэр	Сургалт, мэдээлэл	Сургалт + туслалцаа + бодит кейс
Үр дүн	Иргэн “мэддэг”	Иргэн “ашигладаг”
Бай	Олон нийт	Ялангуяа эмзэг, дуу хоолой сул бүлэг

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр 2018-2023

Хөтөлбөрийн зорилго:

Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахим болон цахим бус байдлаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэх замаар бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2018 оны 2 сарын 14-ний өдөр Засгийн газрын 50-р тогтоолоор батлагдсан.

Бүх нийтийн эрх зүйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний зөвлөл – ХЗҮХ ажлын алба

Үндэсний хөтөлбөр нь эрх зүйн хувьд чадавхжуулах буюу legal empowerment –ын гол элементүүдийг бодлогын түвшинд хамруулж, олон талын хамтын ажиллагаа, уялдаа чухал болохыг тодорхойлсон бөгөөд үзэл баримтлал, агуулгын хувьд өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй байна.

Зорилт 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролын агуулга, арга зүйг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.

3.1.2. иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан зорилтот бүлэгт тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэн, өндөр настан, хүүхдэд ээлтэй, тэдгээрийн нас, сэтгэхүйн онцлог, нийтлэг болон тусгай хэрэгцээ шаардлагад нь тохирсон эрх зүйн боловсролын агуулгыг хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйд нийцүүлэн боловсруулах;

3.1.5. иргэдэд эрх зүйн болон хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээх, тэднийг чадавхжуулах, хүний эрхийн зөрчлийг ялгаж таних, эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг эзэмшүүлэх эрх зүйн шаталсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх;

3.1.6. хууль зүйн туслалцааны 2 шатлалтай үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, эрх зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны чанар, хүртээмжийг сайжруулах;

3.1.7. хууль зүйн туслалцааны анхан шатны үйлчилгээний бодит хэрэгцээ шаардлагыг тогтоож, шийдвэрлэх шаардлагатай бодлогын шийдлийг тодорхойлох чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг тогтмол хийж, үр дүн, үр нөлөөг үнэлж тооцдог болох.

Зорилт 2. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай техник, санхүү, хүний нөөцийг бүрдүүлж, тогтсон мэдээллийн сувгуудыг бий болгон тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.

3.2.1. эрх зүйн хөтчийн тогтолцоо бий болгох;

3.2.2. эрх зүйн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх боломжийг өргөтгөх;

3.2.3. эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгаанд мэдээллийн технологийг ашиглах;

3.2.5. хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдэд эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүний нөөц (дохионы хэлний хэлмэрч, сэтгэл зүйч)-ийг бэлтгэх;

3.2.6. төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд мэргэшсэн эрх зүйн хөтөч ажиллуулах.

Хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө:

4.1.1. иргэд хаана, ямар нөхцөлд амьдарч байгаагаас үл хамааран эрх зүйн үйлчилгээ, мэдээллийг саадгүй авах нөхцөл бүрдэнэ;

4.1.2. иргэд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хуулийн хүрээнд хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх чадвар, боломж нэмэгдэнэ;

4.1.3. төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо нэмэгдэж, төрийн байгууллагаас гарах аливаа шийдвэр нь хүний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх нөхцөл бүрдэнэ;

4.1.5. хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх зарчмыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэх, хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн эрх зүйн ухамсар дээшилнэ.

4.2.1. иргэд эрхээ эдлэх, баталгаажуулах боломж бий болсноор амьжиргаагаа дээшлүүлэх бололцоо нэмэгдэнэ;

4.2.2. иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх иргэдийн чадвар нэмэгдсэнээр бусдын буруутай үйл ажиллагааны улмаас учрах эдийн засгийн хохирол буурна;

4.2.3. эрх зүйн мэдээлэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх цахим сүлжээг нэвтрүүлснээр эрх зүйн мэдээлэл, туслалцаа авахад хялбар болж, зардал буурна;

4.2.4. хуулийг хүндэтгэн сахин биелүүлэх иргэдийн ухамсар дээшилснээр гэмт хэрэг, зөрчил буурна.

Туршлага, сургамж

- ▶ Иргэний боловсрол хичээл – Агуулга, клиник туршилтын арга барил
- ▶ Шүүмжлэлт / эргэцүүлэлт сэтгэлгээ, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх, хамгаалах арга чадварт сургах
- ▶ Хууль зүйн клиник сургалт, үйлчилгээ – Хууль зүйн анхан шатны үйлчилгээний хүртээмж
- ▶ Төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо
- ▶ Иргэдийн эрх зүйн чадавхын өнөөгийн байдал, хэрэгцээ шаардлагын судалгаа
- ▶ Бодлогын баримт бичиг, олон талын хамтын ажиллагаа, бодлогын уялдаа
- ▶ Эрх зүйн хөтчийн тогтолцоо
- ▶ Эрх зүйн цахим хөтөч www.e-khutuch.mn
- ▶ Хуульчдын про боно үйл ажиллагаа

Цаашид – хэрэглээ бодит хэрэгцээнд суурилсан мэдлэг ур чадвар бий болгох

- ▶ Хүүхдүүд, Залуучууд, Насанд хүрэгчид, Ахмад настнуудад болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зэргээр мэдлэг, мэдээлэл, үйлчилгээ, тусламж хүргэх арга барилыг оновчтой тодорхойлох
 - ▶ Шударга ёс, Хүний эрх, Хуулийн талаар мэдлэг олгох – албан болон албан бус
 - ▶ Мэдээллийн шинэлэг, хүртээмжтэй, тохиромжтой сувгууд
 - ▶ Хэрэгцээ шаардлагад нийцсэн байх
 - ▶ Бусад үйлчилгээ дэмжлэгтэй уялдсан хүртээмжтэй байх
 - ▶ Төрийн зүгээс өөрийн санаачилгаар эрсдэл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хууль зүйн үйлчилгээ, мэдээллийг хүргэж мэдээлэхэд анхаарах



Анхаарал тавьсанд
баярлалаа!